



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027

И-мэйл: info@fchm.edu.mn

2025. 12. 24 № 1/1953

танай _____-ны № _____-т

Тайлан хүргүүлэх тухай

Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/346 дугаар тушаалаар баталсан “Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам” болон тус газраас ирүүлсэн 2025 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 9/5903 дугаартай албан бичгийн дагуу Улсын нэгдүгээр төв эмнэлгийн 2025 оны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дараах тайлангуудыг хавсралтаар хүргүүлж байна.

1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, батлагдсан төлөвлөгөө.

2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтийн тайлан болон холбогдох хавсралтууд.

3. Хэрэглэгчийн үнэлгээний тайлан.

Хавсралт 293 хуудастай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.БЯМБАСҮРЭН

142252928

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (сая. төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	2025 онд хүрэх зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэт гэлийн хувь
ЗОРИЛГО: ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛЖ, ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ, ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАН БАЙГУУЛЛАГЫН СОЁЛЫГ ТӨЛӨВШҮҮЛЭХ, САНХҮҮГИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ							
ЗОРИЛТ 1: Эрүүл мэндийн сайдаас тусгайлан үүрэг болгосон арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх							
1.1	ЗГҮАХ 2.3.4.1 Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалтад орсон меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн мэс заслыг нэвтрүүлэх хүний нөөцийг сургаж бэлтгэнэ.	-	Бэлтгэгдсэн эмч, эмнэлгийн мэргэжилтний тоо	-	1-2 эмч бэлтгэгдсэн байна	Меньерийн өвчний хүнд хэлбэрийн үеийн болон чихний мэс засал эмчилгээг нэвтрүүлэх чиглэлээр Малайз Улсын Малай их сургуулийн эмнэлэгт ЧХХСМЗТ-ийн их эмч 3.Мэндсайхан мэс засал эмчилгээний чиглэлээр, оношилгоо буюу тэнцвэр судлалын чиглэлээр их эмч Г.Мядаг нар тус бүр 3 сарын хугацаатай сургалтад хамрагдсан.	100%
1.2	МУХТ 3.3.11 Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний тохиолдлыг бууруулах зорилгын хүрээнд тулгуур эрхтний төрөлхийн дутуу хөгжил, олдмол гажиг, эмчлэхэд төвөгтэй согогуудад сэргээн засах мэс заслыг хийнэ.	16.0 (эрүүл мэндийн даатгал)	Хийгдсэн мэс заслын тоо	Эмчийн баг бэлтгэгдсэн, тоног төхөөрөмжтэй	3 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Тулгуур эрхтний төрөлхийн дутуу хөгжил, олдмол гажгийг эмчлэх чиглэлээр эмчийн баг бэлтгэгдсэн. Эмчлэхэд төвөгтэй согогууд, сэргээн засах мэс засал хийх чиглэлээр өвдөг, түнх, мөрний үений мэс заслыг тогтмол хийж эхлээд байна. 2025 онд шинээр: 1. Бугалга ясны хавдрын үед тахилзуур ясаар орлуулан сэргээх мэс засал -1 2. Мөр эргүүлэгч шөрмөсний сэргээх боломжгүй том хэмжээний урагдлын үед синтетика шөрмөс ашиглан	100%

						сэргээх мэс засал -3 тохиолдолд тус тус хийсэн.	
						Төвлөрлийг бууруулах зорилгын хүрээнд гар, сарвуу, хөл тавхайн мэс заслуудыг хийж эхлээд байгаа бөгөөд хөлийн хуруу засах “Shevron osteotomy” мэс заслыг 3 тохиолдолд хийсэн байна.	
1.3	МУХТ 3.3.11 Төвлөрлийг бууруулах, тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хүзүүний хорт хавдрын нээлттэй мэс заслын тусламж үйлчилгээг эхлүүлнэ.	45.0 (эрүүл мэндийн даатгал)	- Хийгдсэн мэс заслын тоо - Бэлтгэл ажлын тайлан	-	3-5 тохиолдолд амжилттай хийсэн байна.	2025 оны 1-6 сард УНТЭ-ийн ЧХХСМЗТ-ийн төвөнхийн баг болон ЭНМЗТ-ийн багууд ХСҮТ-ийн зөвлөх эмч Г.Пүрэвдоржтой хамтран төвөнхийн хорт хавдрын үеийн төвөнх бүтэн авах мэс засал-1, төвөнхийн хавдрын дараах нөхөн сэргээх мэс засал-1, цагаан мөгөөрсөн хоолойн хавдар тайрах мэс засал-1, эрүүн доорхи шүлсний булчирхайн хавдар тайрах мэс засал-1 тус бүр амжилттай хийсэн. <u>Хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр:</u> Толгой, хүзүүний хорт хавдрын мэс заслын чиглэлээр ХСҮТ-ийн ТХМЗТ-т их эмч М.Лутзул 1 жилийн хугацаатай суралцаж төгссөн бөгөөд 2025 оны намрын элсэлтээр их эмч Д.Нямсүрэн, их эмч З.Мэндсайхан нар суралцаж байна. Мөн их эмч Д.Нямсүрэн нь тус чиглэлээр БНСУ-д 6 сарын хугацаатай сургалтад хамрагдаж байна.	100%

1.4	МУХТ 3.3.11 Цусны ба Хэрх, үений эмгэгийн тусламж үйлчилгээг дүүрэг болон бүсийн оношилгоо, эмчилгээний төвд үзүүлэх эмч нарыг сургаж бэлтгэнэ.	-	- Сургаж бэлтгэсэн эмч, мэргэжилтний тоо - Тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчийн тоо	Сургалт зохион байгуулах бүрэн боломжтой	2-3 дүүрэг, 1-2 БОЭТ-д Цусны ба Хэрх, үений эмгэгийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байна.	Төвлөрлийг сааруулах ажлын хүрээнд ЦЭСЧШСТ нь аймаг, дүүрэгт цусны эмч бэлтгэх зорилгоор дараах хөтөлбөрүүдийг боловсруулж, ЭМЯ-ны дэргэдэх цусны салбар зөвлөлөөрөө хэлэлцүүлэн ЭМХТ-д хүргүүлсэн. Үүнд: 1. Хүний их эмчийн “Үүдэл эс шилжүүлэн суулгалт” мэргэжил дээшлүүлэх 3 сарын хөтөлбөр 2. Хүний их эмчийн “Цус судлал” мэргэжил дээшлүүлэх 3 сарын хөтөлбөр Мөн ХҮСҮСТ-өөс хүний их эмчийн “Хэрх, үе судлал” мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалтын хөтөлбөрийг боловсруулан, ЭМЯ-ны дэргэдэх дотрын мэргэжлийн салбар зөвлөлөөр хэлэлцүүлж, дэмжигдсэн тохиолдолд ЭМХТ-д батлуулахаар хүргүүлнэ.	50%
1.5	Хоол боловсруулах замын дурангийн сургалтын төв байгуулах төслийг эхлүүлж бэлтгэл ажлыг хангана.	-	- Сургалтын хөтөлбөр, төсөв - Төлөвлөсөн арга хэмжээ	3 багш эмчтэй	Тухайн жилийн төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Гастроэнтерологийн төвийн эмч нар дурангийн сургалтын төв байгуулах төслийг англи, монгол хэл дээр бичиж, төсөв санхүүгийн дэмжлэг хүссэн хүсэлтийг Япон улсын Жайка ОУБ-ын Өвсний Үндэс хөтөлбөрт, БНСУ-ын КОЙКА ОУБ-т, “Дезерет” ОУБ-т, ЭМЯ-нд тус тус хүргүүлсэн. ГЭТ-ийн дурангийн хэсэгт дурангийн сургалтын өрөөг бэлтгэсэн.	70%

1.6	Сүхбаатар дүүргийн “Сэлбэ” нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллах, салбар эмнэлгийн хэмжээнд хөгжүүлнэ.	-	- Сургасан эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтний тоо - Мэргэжил арга зүйгээр хангасан чиглэл	-	Эрчимт эмчилгээ, яаралтай тусламж, мэс заслын тусламж үйлчилгээг эхлүүлсэн байна.	УНТЭ нь Сүхбаатар дүүргийн Сэлбэ нэгдсэн эмнэлэгтэй 2025.04.16-нд УНТЭ 39/25 дугаартай хамтын ажиллагааны санамж бичгийг үзэглэсэн. 2025 оны 3 дугаар сард УНТЭ-ийн удирдлагын баг Сэлбэ нэгдсэн эмнэлэгт очиж ажилласан бөгөөд нүд судлал мэс заслын тасгийн эмч нар 1 удаа хамтарсан үзлэг зохион байгуулсан. Гэрээний дагуу 2025 онд эрчимт эмчилгээний сувилахуйн чиглэлээр -1, хими эмчилгээ, хавдрын сувилахуйн тусламж үйлчилгээний чиглэлээр -2, спирогаммын оношилгооны чиглэлээр -1 нийт 4 сувилагч ажлын байрны сургалтад хамрагдсан. Сэлбэ нэгдсэн эмнэлэг нь одоогийн байдлаар ЭМДЕГ-тай тусламж үйлчилгээний гэрээ байгуулаагүй, хагалгааны өрөө нь ашиглалтад ороогүй, мэс заслын тусламж үйлчилгээ үзүүлж эхлээгүй байгаа тул мэргэжил арга зүйгээр хангах сургалтын үйл ажиллагаа түр зогссон байна.	100%
1.7	Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	-	Хийгдсэн мэс тоо, төрөл	2022 онд хамтын ажиллагааны гэрээ байгуулсан	Мэс заслын тоо болон төрлийг нэмэгдүүлсэн байна.	УНТЭ нь Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийг мэргэжил арга зүйгээр хангах хамтын ажиллагааны санамж бичиг буюу УНТЭ 134/25 гэрээг 2025.11.28-ны өдөр үзэглэсэн бөгөөд ерөнхий мэс засал, бөөр шээс дамжуулах замын болон бүдүүн шулуун	70%

						гэдэсний мэс засал, чих хамар, хоолойн мэс засал, дотоод шүүрэл, зүрх судас, гастроэнтерологи, эрчимт эмчилгээний чиглэлээр хамтран ажиллаж эхлээд байна. ЭМТҮЧАБА нь тус эмнэлгийн 6 хүнд өвчтөнд хамтарсан хэлэлцүүлэг хийж асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд хамтран ажиллах тусламж үйлчилгээний чиглэлээр ажлын байрны сургалтууд зохион байгуулж эхлээд байна.	
ЗОРИЛТ 2: Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулах							
2.1	ДОТ-ийн Цөмийн онош зүйн хэсэгт Олон улсын атомын энергийн газрын дэмжлэгтэй Спект СТ аппаратыг хүлээн авч суурилуулан ашиглалтад оруулна.	3,000.0 ОУАЭГ	–Гэрээ –Ашиглалтад оруулсан акт -Үйлчлүүлсэн иргэдийн тоо	Ханган нийлүүлэх гэрээ байгуулагдсан	Спект СТ аппарат үйл ажиллагаанд орж нийт 1000 орчим иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.	Олон улсын атомын энергийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж буй МОН/6023 төслийн хүрээнд Монгол улсын 2 дахь СПЭКТ/КТ аппарат нь УНТЭ-т нийлүүлэгдэн Унгар улсын инженерүүд суурилуулалтын ажлыг хийсэн бөгөөд 2025.06.23-нд албан ёсоор нээлтээ хийж үйл ажиллагаа эхэлсэн. 2025 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар нийт 1202 үйлчлүүлэгч шинжилгээ, оношилгоонд хамрагдсанаас шинээр суурилагдсан Спект СТ аппаратаар 168 удаагийн оношилгоо хийсэн байна.	100%

2.2	Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг сайжруулна.	-	-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	ЭМС-ын 2024 оны А/112 тоот “Журам батлах тухай” тушаал	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Тусламж үйлчилгээний эрсдэлээс сэргийлэх, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг үнэлж дүгнэн үр дүнг тооцон ажиллах, тусламж үйлчилгээний чанар сайжруулах зорилгоор Эмнэлгийн захирлын 2025 оны А/150 дугаар тушаалаар чанарын багийн гишүүдийн тоог нэмж өргөтгөн 80 гишүүнтэй чанарын багийг байгуулсан. 2025 оны туршид 46 удаагийн чанарын хэлэлцүүлэг, зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулсан. Мэс заслын анагаах ухааны салбарын чанарын багууд нийт 18 удаагийн чанарын хурал хийж, 1 удаа чанарын өдөрлөг зохион байгуулсан. Эмнэлзүйн тусламж үйлчилгээнд мөрдөн ажиллаж буй тушаал шийдвэрт үнэлгээ хийлгэн, шинэчлэх шаардлагатай 25 журмыг шинэчлэн боловсруулж баталж эхлээд байна. Үйлчлүүлэгчийг хүлээн авч уулзах уулзалтын өрөөг тохижуулсан. Эмнэлгийн хэмжээнд эмнэлзүйн болон эмнэлзүйн бус гэсэн 2 чиглэлээр 48 эрсдлийг бүртгэж нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Байгууллагын эрсдэлийн нэгдсэн сан үүсгэн, эрсдэлийн бүртгэл	100%
-----	---	---	--	---	--	---	------

						хийх үйл ажиллагааг тогтмолжуулсан. Үл тохирол тохиолдлыг QR кодоор бүртгэж хариу арга хэмжээг авч ажилласан. Тохиолдол 74 бүртгэж хариу арга хэмжээ авч ажилласан.	
2.3	Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн явцад мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийх үйл ажиллагааны журам батлуулж мөрдөн ажиллана.	-	- Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан журам - Хэрэгжилтийн тайлан	Журам батлагдаагүй	Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байна.	ЭМТҮЧАБА, МХНТ хамтран “Амбулаториор хийгддэг мэс ажилбар, үйлдлийн явцад мэдээгүйжүүлэг, ажилбарын үеийн тайвшруулалт хийх үйл ажиллагааны журам” боловсруулсан. Журмыг МХНТ-ийн нийт эмч нараар хэлэлцүүлж, ЭМТҮЧАБА-аар хянуулан эмнэлгийн захирлын 2025.12.05-ны өдрийн А/358 тоот тушаалаар батлуулсан.	100%
2.4	Харилцааны бэрхшээлтэй буюу аман харилцаа үүсгэх боломжгүй үйлчлүүлэгчийг таних аргыг нэвтрүүлж, холбогдох журмын хэрэгжилтийг ханган ажиллана.	-	Хяналтын тайлан болон хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Эмнэлгийн захирлын 2024 оны А/99 тоот тушаалаар журам батлагдсан	Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж хэвшсэн байна.	“Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо”, УНТЭ-ийн НЭМА, СЗУЭТ-ууд хамтран 2025.05.26-ний өдрөөс “Харилцааны анхан шатны дохионы хэл” 3 удаагийн 12 багц цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 29 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.	100%
2.5	Өндөр эрсдэл үүсгэж болзошгүй эмийн аюулгүй байдлыг хангах, хяналтыг сайжруулах, эрсдэлээс сэргийлэх арга хэмжээ авч ажиллана.	-	Хяналтын тайлан болон хяналтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Тогтмол зохион байгуулагддаг	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	УНТЭ-т хэрэглэгдэж буй 410 аад нэр төрлийн эм тарианаас 11 нэр төрөл нь ижил савалгаатай өндөр эрсдэлт эм байдаг бөгөөд үүнээс 6 нэр төрөл нь дотоодын үйлдвэрийн Айвико ХХК, Цомбо ХХК, Нахиа ХХК, Мөнхийн тун ХХК үйлдвэрийн бүтээгдэхүүн байна. Эмзүйн албанаас эмнэлгийн хэмжээнд хэрэглэгдэж буй	

						1. Сонгодог өндөр эрсдэлт эм, 2. Ижил дуудагддаг өндөр эрсдэлт эм, 3. Ижил харагддаг өндөр эрсдэлт эмийн мэдээллээр таниулах зурагт хуудас бэлтгэн цахимаар болон нийт эмч, эмнэлгийн мэргэжилтний яриан дээр мэдээллийг хүргэн ажиллаж байна. Мөн төв, тасгуудад эмийн нэр, андуурагдаж болзошгүй эм, тарианы зургийг өнгөтөөр хэвлэн мэдээллийн самбарт байршуулж, ижил савлагаатай, адил харагддаг эмийн нэгж тунгийн савлагаан дээр анхааруулах тэмдэг наан хяналт тавин ажилласан. 2025 онд ижил дуудагддаг, ижил харагддаг өндөр эрсдэлт эмийн хэрэглээнд алдаа тохиолдол бүртгэгдээгүй ажилласан байна.	100%
2.6	ОЭТН-ийн халдварыг бууруулах, тандалт хяналтыг сайжруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлнэ.	-	Хяналтын тайлан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан	Хийгдэж байсан	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	2025 оны туршид Эмнэлзүй, эмгэг судлалын нэгдсэн лабораторт хийгдсэн нян судлалын шинжилгээгээр ОЭТН-ийн нийт 1194 эерэг сорьц илэрснийг шуурхай мэдээлэх тогтолцооны дагуу ХСХА-нд мэдээлсэн. Үүнд: ➤ Амбулаторид-399 ➤ Яаралтай тусламжийн тасагт-102 ➤ Дотрын тасагт-222, ➤ Мэс заслын тасагт-361.	100%

						Үүнээс хэвтэн эмчлүүлэх тасагт илэрсэн 693 тохиолдолд ХСХА-наас нарийвчилсан тандалт судалгааг хийхэд сэжигтэй-40, батлагдсан-20 тохиолдол байгаа бөгөөд ЭТҮХХ-ын сэжигтэй, олон эмэнд тэсвэртэй нянгийн 40 тохиолдлыг ХӨСҮТ-д сэжигтэй тохиолдлоор мэдээлээд байна. <i>(Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан)</i>	
2.7	Үйлчлүүлэгчийг дэмжих алба байгуулна.	-	– Батлагдсан тушаал – Шийдвэр – Ажиллах дүрэм	-	Үйлчлүүлэгчийг дэмжих албатай болсон байна.	“УНТЭ-ийн дүрмийг шинэчлэн батлуулах хүсэлт болон дүрмийн шинэчилсэн төсөл”-ийг 2025 оны 06 дугаар сард ЭМЯ-нд хүргүүлсэн бөгөөд шинэчлэгдсэн дүрмийн дагуу батлагдах бүтцэд “Үйлчлүүлэгчийг дэмжих алба”-ыг байгуулан ажиллахаар төлөвлөсөн.	70%
2.8	“Сувилагчийн нэг өдөр” аян, өдөрлөгийг зохион байгуулна.	-	Өдөрлөгийн удирдамж, тайлан	Жил бүр зохион байгуулагддаг	Өдөрлөг зохион байгуулагдсан байна.	Олон Улсын сувилагчийн өдрийг угтаж Сувилахуйн албанаас сувилагч нарын мэргэжил, үйл ажиллагааг суртачлах зорилго бүхий аяныг зохион байгуулж, аяны хүрээнд Reel видео бичлэгийн уралдааныг зохион байгуулсан. Мөн mass.mn, arslan.mn мэдээллийн цахим хуудсуудтай хамтран шилдэг сувилагч нарынхаа талаар мэдээ контент бэлтгэн ард иргэдэд хүргэсэн.	100%

ЗОРИЛТ 3: Санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, нөөцийн удирдлагыг сайжруулах

3.1	Эмнэлгийн e-Health, VERITECH ERP санхүүгийн системүүдийг өгөгдөл солилцдог болгож улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн хөгжүүлэлтийг программд хийнэ.	20.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Хийсэн ажлын тайлан - Хөгжүүлсэн модулийн тоо - Акт дүгнэлт	Эм эмнэлгийн хэрэгсэл, хоол, угаалгын зардлыг механик аргаар бүртгэдэг	Үйлчлүүлэгчийн зардлыг VERITECH ERP санхүүгийн системд харилцагч, онош тасгаар шууд хөрвүүлдэг болсон байна	Эрүүл мэндийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн А/190 тоот тушаалаар “Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, хэрэглэгчийн сэтгэл ханамж, санхүү нөөц бүртгэлийн системийн процессыг оновчтой, үр ашигтайгаар зохион байгуулах, нөхцөл байдлын дүн шинжилгээ хийж, цахимжуулалтыг эрчимжүүлэх” ажлын төсөв батлагдан, УНТЭ нь агуулахын шинэ програм худалдан авах ажлыг зохион байгуулж 2025 оны 08 дугаар сараас эхлэн програмын хөгжүүлэлт хийгдсэн. Тус програмын хөгжүүлэлтээр 2011 оноос хойш бүртгэгдсэн эм, эмнэлгийн хэрэгслийн нэршлийг цэгцэлж, олон улсын АТС кодлолын дагуу кодолсон. Мөн уг ажилтай зэрэгцүүлэн МТА нь нэгж тунгийн савлагааны ухаалаг технологийг Эмзүйн алба, Техникийн алба, Санхүү бүртгэлийн алба, Эдийн засгийн албатай хамтран Монгол улсад анх удаа нэвтрүүлсэн. Эм, бараа материалын агуулахын нэгдсэн шинэ системийг нэвтрүүлэх явцад e-Health програм дээр 2 модулийг нэмэлтээр хөгжүүлж e-Health болон Veritech Erp програмууд хоорондоо өгөгдөл солилцдог болж, тайлан гаргах үйл явц бүрэн автоматжиж, агуулахын үлдэгдэл	100%
-----	--	-----------------------------------	---	--	---	---	------

						бодит цагийн горимоор харагддаг болсон.	
3.2	ЭМДЕГ-тай байгуулсан тусламж үйлчилгээ худалдах, худалдан авах гэрээнд үндэслэн эмнэлзүйн төв, тасгуудын орлого зарлагыг тооцож, нотолгоонд суурилсан төлөвлөлт хийн ажиллана.	-	- Хийгдсэн тооцоолол, төлөвлөлт - Төв, тасгийн дарга, эрхлэгч нартай байгуулсан үр дүнгийн гэрээ	ЭМДЕГ-тай байгуулсан гэрээ	Орлого, зарлагын төлөвлөлтийг хянаж удирдах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	Эмнэлзүйн алба нь эмнэлгийн захирлаар удирдуулан эмнэлзүйн төв, тасгийн эрхлэгч, дарга нартай нийт 8 удаагийн уулзалт зохион байгуулж даатгалтай байгуулсан гэрээний дүнд тааруулан төлөвлөлт хийж, тухай бүрд холбогдох удирдлагуудад танилцуулга хийж байсан. Мөн Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04-р тогтоолын талаар, битүүмж, даатгалын “Чанар, төлбөрийн хяналт”-ын талаар сургалтуудыг тогтмол зохион байгуулж нотолгоонд суурилсан төлөвлөлтийг хийж ажилласан.	100%
3.3	Амбулаторийн эмийн сангийн тусламж үйлчилгээг өргөжүүлнэ	300,0 (үйл ажиллаг ааны орлого)	- Нэгж тунгийн системээр эм олгогдсон үйлчлүүлэгчийн тоо - Борлуулалт хийсэн мөнгөн дүн	-	Амбулаторийн эмийн сангийн орлогыг 15-20%-аар нэмэгдүүлсэн байна.	1. 2025 орны туршид амбулаторын эмийн сангийн борлуулалтын орлогыг 300,0 сая төгрөгөөр төсөвлөсөн боловч амбулаторын хэсгийн бохир, цэвэр усны шугамын засварын ажил 2025 оны 3 дугаар сараас эхлэн 10 дугаар сард дуусаж үйл ажиллагаа жигдэрсэн бөгөөд дээрх шалтгаанаас борлуулалтын орлого буурсан байна. Нийт жилийн борлуулалт эхний 11 сарын байдлаар 139.0 сая төгрөг байна. 2. Амбулаторийн эмийн сангийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх олон улсад хэрэгжүүлдэг	90%

						дараагийн арга хэмжээ нь хэвтэн эмчлүүлээд гарсан иргэнд эмчийн бичсэн эмчилгээг нэгж тунгийн системээр савалж олгох, борлуулалт хийх бөгөөд 2025.12.01-ний өдрийн байдлаар байдлаар эм зүйн алба нь эмнэлзүйн 10 тасаг, төвөөс хэвтэн эмчлүүлсэн үйлчлүүлэгч эмнэлгээс гараад үргэлжлүүлэн уух эмийн судалгааг авч, 2026 онд худалдан авалтыг хийх, эмийн автомат машинаар нэгж тунгийн системээр савлах, эмийн хайрцгийг захиалах ажлуудыг хийж гүйцэтгээд байна.	
3.4	Нийт эмнэлзүйн төв, тасгуудад нэхэмжлэлийн хяналтын шалгуурын дагуу явцын болон төлөвлөгөөт хяналт хийх, хяналтын үр дүнд гарсан алдаа зөрчлөөс сэргийлсэн сургалт, мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулна.	-	- Хяналт хийсэн тоо, төрөл - Хяналтын тайлан - Авсан арга хэмжээ	2024 онд нийт хасагдлын 4%	Нийт хасагдлыг 3.5% болгон бууруулах	УНТЭ-ийн Эмнэлзүйн албаны даатгалын хэсгээс ЭМДҮЗ-н 2022 оны 12 дугаар тогтоолын дагуу нийт эмнэлзүйн төв тасгуудын тусламж үйлчилгээ болон өвчний түүхэнд явцын хяналтыг тасралтгүй хийн ажилласан. 2025 оны эхний 11 сард эмнэлгээс гарагчийн нийт 15,200 өвчний түүхэд хяналт хийж, 8601 түүхэнд зөрчлийг илрүүлэн, холбогдох тасгийн эмч, сувилагчтай утсаар холбогдон залруулсан. 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс 11 дүгээр сарын 30-ний хооронд дотрын болон мэс заслын тасгийн нийт 16 эмч нэхэмжлэлийн хяналтын шалгуурын дагуу цахим	100%

						өвчний түүхэнд нарийвчилсан хяналт хийж ажилласан. 2025 оны эхний 10 сарын байдлаар нийт хасагдал 35%, эмнэлзүйн шалгуур хангаагүй хасагдал 59%-р тус тус буурсан байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар хасагдал нийт нэхэмжлэлд эзлэх хувь 2,1%, 2024 оны мөн үетэй харьцуулбал 1%-р буурсан байна. 2025 онд эмнэлзүйн албанаас эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 04-р тогтоолын талаар, битүүмж, даатгалын “Чанар, төлбөрийн хяналт”-ын талаар эмч нарт 4 удаа, ахлах сувилагч нарт 2 удаа, тасагчилсан ажлын байрны сургалт 10 удаа зохион байгуулсан.	
3.5	Амбулаторийн хэсэгт архаг өвдөлт намдаах тусламж үйлчилгээг үзүүлнэ.	-	-Журам -Тусламж үйлчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	Амбулаторийн хэсэгт архаг өвдөлтийн тусламж үйлчилгээг үзүүлдэг болсон байна.	МХНТ-ийн их эмч А.Мягмар Тайвань улсад архаг өвдөлтийн эмчилгээний чиглэлээр суралцаж ирсэн. 2025 онд амбулаторийн хэсэгт архаг өвдөлтийн үзлэгийн кабинетийг шинэчлэн тохижуулж, засварласан бөгөөд нийт 3554 үзлэг хийгдэж, үүнээс архаг өвдөлт намдаах ажилбар 385 удаа хийгдсэн.	100%

ЗОРИЛТ 4: Оношилгоо, эмчилгээ, сувилахуйн дэвшилтэт технологи, инновацыг нэвтрүүлэн нутагшуулах

4.1	Бөөрний реципиентэд дурангаар бөөр шилжүүлэн суулгах шинэ технологийг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн мэс заслын тоо	Мэргэжлийн баг бэлтгэгдсэн	1-2 тохиолдолд амжилттай хийсэн байна	Тус технологийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган 2025 онд ЭШСТ-ийн Бөөр шилжүүлэн суулгах баг нь БНСУ болон МУ-д үйл ажиллагаа явуулдаг “Ротари клуб”-тай хамтран БШС багийн ахлагч М.Эрдэнэсайхан болон 2 бөөрний эмч, 3 мэс заслын эмч, 1 гистологийн эмчийг БНСУ-д Сөүлийн их сургуулийн эмнэлэгт 14 хоногоос 1 сарын хугацаатай сургаж бэлтгэсэн. Мөн тус технологийг нэвтрүүлэхэд Da Vinci буюу робот мэс заслын хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмж шаардлагатай бөгөөд тоног төхөөрөмжийн жагсаалт болон техник үзүүлэлтийг боловсруулсан.	50%
4.2	Донорын элгийг дурангаар тайрах мэс заслын технологийг нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийсэн тохиолдлын тоо	МУ-д анх удаа хийгдэнэ	1-2 тохиолдолд амжилттай хийсэн байна	2025.02.22-ны өдөр Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн элэг шилжүүлэн суулгах мэс заслын баг БНСУ-ын Асан эрүүл мэндийн төвийн эмч нартай хамтран донорын мэс заслыг хэвлийн дурангийн аргаар анх удаа 1 тохиолдолд амжилттай хийсэн.	100%
4.3	Нүдний даралт ихсэх өвчний үед хийгддэг MIGS мэс заслыг нэвтрүүлж, нутагшуулна.		Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Гадны эмч нартай хамтарч хийдэг	3-5 үйлчлүүлэгчид мэс засал хийсэн байна.	УНТЭ-ийн HCM3T-ийн эмч нар Австралийн Sight For All сангийн глаукомын эмч, зочин профессоруудтай хамтран 2025 оны 06 сарын 10-ны өдөр нүдний даралт ихсэх өвчний үед хийгддэг	100%

						бичил хүрцэт /MIGS/ мэс заслыг 1 тохиолдолд амжилттай хийсэн.	
4.4	Хоол боловсруулах замын дурангийн эмчилгээний шинэ аргыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ. - Дурангаар ходоодны хавдрыг бүх давхаргаар бүтнээр нь хуулах (EFTR)	-	Амжилттай хийсэн тохиолдлын тоо	Эмч бэлтгэгдсэн, дурангийн тоног төхөөрөмжтэй	1-2 үйлчлүүлэгчид эмчилгээг хийсэн байна	Эмчилгээг хийх эмчийн баг бэлтгэгдсэн. Тус эмчилгээнд шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг захиалгад оруулсан. Төсөв санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэхэд эмчилгээ хийх бэлтгэлийг бүрэн хангасан.	50%
4.5	Төвөнх, залгиур, толгой хүзүүний лазерын эмчилгээг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг эхлүүлнэ.	-	- Бэлтгэгдсэн эмч нарын тоо - Бичигдсэн төсөл	-	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	<u>Хүний нөөцийг бэлтгэх чиглэлээр:</u> УНТЭ-ийн ЧХХСМЗТ нь төвөнх залгиурын мэргэшсэн эмчийн багтай бөгөөд толгой хүзүүний мэс заслын чиглэлээр ХСҮТ-ийн ТХМЗТ-т их эмч М.Лутзулыг толгой, хүзүүний мэс заслын чиглэлээр 1 жилийн хугацаатай суралцуулсан бөгөөд 2025 оны намрын элсэлтээр их эмч Д.Нямсүрэн, З.Мэндсайхан нар суралцаж байна. Мөн их эмч Д.Нямсүрэн нь тус чиглэлээр БНСУ-д 6 сарын хугацаатай сургалтад хамрагдаж байна. Ингэснээр лазер эмчилгээний тоног төхөөрөмжтэй болоход эмчийн баг бүрэн бэлтгэгдсэн байна. Мөн ЧХХСМЗТ нь “Лазер эмчилгээг нэвтрүүлэх” чиглэлээр төсөл бичиж, эмчилгээний заавар удирдамжийг орчуулж эхлээд байна.	100%

4.6	Толгой, хүзүүний хорт хавдрын дурангийн мэс заслыг эхлүүлнэ.	—	- Амжилттай хийгдсэн эмчилгээний тоо - Бэлтгэгдсэн эмч, мэргэжилтний тоо	-	5 тохиолдолд мэс засал хийсэн байна.	2025 онд Чих хамар хоолой, мэс заслын тасгийн хамрын баг хамрын дайвар хөндий болон хамрын хөндийн хорт хавдрыг дурангаар авах мэс заслын 2 тохиолдолд хийн УХТЭ-ийн эмч нартай хамтран хүзүүний тунгалагийн булчирхай түүх хагалгааг хийсэн ба төвөнх залгиурын баг нь Хавдрын зөвлөх эмч Пүрэвдоржийн удирдлаган доор төвөнхийн хорт хавдрын 3 тохиолдолд тус бүр амжилттай хийсэн.	100%
4.7	Хорт хавдартай өвчтөнүүдийн ясны үсэрхийллийн өвдөлт намдаах эмчилгээг шинээр нэвтрүүлнэ.	—	—Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	5 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Тус эмчилгээ нь хорт хавдартай өвчтөнүүдийн амьдралыг чанарыг сайжруулдаг бөгөөд эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд ОУАЭА-ийн (IAEA)-ийн FS-MON6023-2406888 төслийн дэмжлэгтэйгээр ЦОЗТ-ийн 1 эмч Их Британи улсад 1 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтад, физикч Г.Мөнхцэцэг Сингапур улсын Үндэсний эмнэлгийн Цөмийн онош зүйн тасагт 2 сарын хугацаатай мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан. Тус эмчилгээнд хэрэглэгдэх изотоп болон химийн холбогч бодисын үнийн судалгаа хийгдэж, эмчилгээний арга, аргачлалыг орчуулж, олон улсын практикийг судалсан. Төсөв санхүүгийн асуудал шийдвэрлэгдвэл тус	90%

						эмчилгээг эхлүүлэхэд бэлэн болсон.	
4.8	Үгийн аудиометрийн шинжилгээг оношилгоонд нэвтрүүлж үндэсний хэмжээнд хөгжүүлнэ.	Төсөл, хөтөл бөр	- Стандарт батлагдсан байна - Оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	50 үйлчлүүлэгчид хийсэн байна.	ЧХХСМЗТ-ийн сонсголын багийн эмч нар тус стандартыг боловсруулан УНТЭ-ийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж, ЭМЯ-нд хүргүүлсэн. “Стандарт хэмжилзүйн газар”-ын цахим хуудаст стандартыг байршуулж, санал авсан бөгөөд 2025.11.20-нд СХЗҮТ-өөр стандартыг хэлэлцүүлэн өгсөн санал, зөвлөмжийн дагуу сайжруулан 12 сардаа багтаан батлуулахаар төлөвлөсөн. Мөн үгийн аудиометрийн шинжилгээ хийхэд ашиглагдах тусгай үгийн таблицыг боловсруулан, шинжилгээний жагсаалтыг батлуулсан. Тус шинжилгээг нийт 100 гаруй үйлчлүүлэгчид хийсэн.	100%
4.9	Гуурсан хоолойн уян дурангаар захын байрлалтай үүсгэврээс эдийн шинжилгээ авна.		- Амжилттай хийсэн тохиолдлын тоо	Эмч мэргэжилтэн бэлтгэгдсэн	5-10 тохиолдолд оношилгоог амжилттай хийгдсэн байна.	Уушги, харшил судлалын төвийн 5 эмч, 1 сувилагч Япон улсын Japan Institute for Health Security эмнэлэгт ажлын байрны сургалтад хамруулан хүний нөөцийг бэлтгэсэн. 2025 онд гуурсан хоолойн уян дурангаар захын байрлалтай үүсгэврээс эдийн шинжилгээ авах 8 тохиолдлыг амжилттай хийсэн.	100%
4.10	МУХТ 3.3.16 ICT TENS буюу өвдөлт намдаах зорилгоор ашигладаг цахилгаан	13.0 (төсөл хөтөл бөр)	- Бичигдсэн төсөл - Санхүүжилтийн тайлан	-	Төсөл хэрэгжиж аппарат суурилагдсан байна	Сэргээн засах тусламж үйлчилгээнд өвдөлт намдаах зорилгоор ашигладаг ICT TENS цахилгаан эмчилгээний аппарат	

	эмчилгээний аппаратыг сэргээн засах эмчилгээнд нэвтрүүлнэ.					худалдан авах санхүүгийн асуудлыг нийтэд үйлчлэх төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр шийдвэрлэж, 2025 оны 12 сард ханган нийлүүлэгч байгууллагаас хүлээн авч тусламж үйлчилгээнд ашиглаж эхлээд байна.	100%
4.11	Ходоод, бүдүүн шулуун гэдэс, хөх, өндгөвч болон бусад хавдрын оношилгоонд шаардлагатай 113 гений мутаци тодорхойлох шинжилгээг бүрэн нутагшуулна.	40.0 (үйл ажиллаг ааны орлого)	Шинжилгээ, оношилгоонд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	2024 онд 4 тохиолдолд хийсэн.	Оношилгоог нийт 10 үйлчлүүлэгчид хийсэн байна.	Тус оношилгоог 1 тохиолдолд амжилттай хийсэн байна.	100%
4.12	Үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээг хийхэд шаардлагатай HLA typing 11 локуст тодорхойлох шинжилгээг NGS технологи iSeq 100 төхөөрөмж дээр хийж гүйцэтгэнэ.	100.0 (үйл ажиллаг ааны орлого)	Шинжилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	2024 онд 15 тохиолдолд хийсэн.	Оношилгоог нийт 40 үйлчлүүлэгчид хийсэн байна.	Тус оношилгоог нийт 92 үйлчлүүлэгчид хийсэн. Үүнээс BMT -33 одоо тогтмол хийгдэж байна.	100%
4.13	Мөгөөрсний гэмтлийг үүдэл эс ашиглан эмчлэх технологийг нэвтрүүлнэ.	–	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	УНТЭ-д мезенхимийн үүдэл эс ялгах эмчилгээ хийгдэж байгаагүй	1-2 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Хэрх үе судлал, үе сэргээх төв нь ЦЭСЧШСТ-тэй хамтран өвдөгний гэмтэлтэй 2 өвчтөнд гэмтлийг үүдэл эс ашиглан эмчлэх эмчилгээг амжилттай хийсэн. Мезенхимийн үүдэл эс ялгах ажилбарыг ЦЭСЧШСТ-ийн эмч нар хийсэн.	100%
4.14	Бүдүүн шулуун гэдэсний хорт хавдрын дархлаа эмчилгээг нэвтрүүлж нутагшуулна.	20.0 (үйл ажиллаг ааны орлого)	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	5-10 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Хавдарын хими эмчилгээний 2 эмч бэлтгэсэн, 2025 оны IV дүгээр улиралд Гастроэнтерологийн төвд бүдүүн гэдэсний үрэвсэлт өвчний эмчилгээнд дархлаа эмчилгээг 1	

						үйлчлүүлэгчид амжилттай хийсэн. Мөн адалимумаб эмчилгээг хүнд хэлбэрийн Кроны өвчтэй өвчтөнд эхний курс эмчилгээг хийсэн бөгөөд биеийн байдал тогтвортой, гаж нөлөө гараагүй. Холын үсэрхийлэлтэй элэгний хавдрын эмчилгээний шинэ, дархлаа эмчилгээний бэлдмэлүүд болох Bevacizumab ба Atezolizumab нь МУ-ын эмийн бүртгэлд 2022 онд бүртгэгдсэн бөгөөд ЭМД-д эм нь хамрагдсан тохиолдолд ГЭТ-д тус эмчилгээг хийх бүрэн боломжтой болсон. Мөн БШГМЗТ-т 2 үйлчлүүлэгчид хавдрын дархлаа эмчилгээ хийсэн.	100%
4.15	Гамма пробыг хөх хадгалах, хавдрын хагалгаа болон бамбайн дэргэдэх булчирхайн байршлыг мэс заслын үед ашиглан илрүүлж хагалгаа, эмчилгээний менежментийг сайжруулах технологийг нэвтрүүлнэ.	-	Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	10 тохиолдолд амжилттай хийсэн байна.	УНТЭ-ийн Цөмийн онош зүйн тасаг болон Ерөнхий мэс заслын тасгууд хамтран гамма пробыг ашиглан 1. Бамбайн дэргэдэх булчирхайн байршил тогтоосон 10 тохиолдол 2. Хөхний хорт хавдрын мэс заслын үед харуул булчирхай илрүүлсэн 1 тохиолдлыг тус тус хийж эмчилгээний менежментийг сайжруулсан байна.	100%
4.16	Элэгний анхдагч хавдрын тэжээгч судсаар бөглөх эмчилгээнд химийн тариа ялгаруулагч бөмбөлөг материалаар бөглөх	-	Эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо	-	5 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Drug eluting bead нь элэгний хавдрын эсрэг химийн тарианууд болох doxorubicin, cisplatin-г өндөр концентрациар агуулж, хавдар тэжээгч бичил судсанд удаан хугацаагаар химийн тариаг	

	эмчилгээг практикт нэвтрүүлнэ.					өөрөөсөө байнга ялгаруулдагаараа бусад бөглөгч бодисуудаас илүү давуу талтай, эмчилгээний шинэ технологи бөгөөд 2025 оны 12 сарын байдлаар 7 тохиолдолд эмчилгээг амжилттай хийсэн байна.	100%
4.17	Элэг шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн батлуулна.	-	ЭМС-ын тушаалаар батлагдсан эмчилгээний заавар	ЭМС-ын 2014 оны “Заавар батлах тухай” 177 тоот тушаал	Эмчилгээний заавар зохих хурлуудаар хэлэлцэгдэн ЭМЯ-нд хүргэгдсэн байна.	Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн элэг шилжүүлэн суулгах багийн эмч нар элэг шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулсан. Тус зааврыг УНТЭ-ийн “Эрдэмтдийн зөвлөл”-өөр хэлэлцүүлж, ЭМЯ-нд хүргүүлсэн.	100%
4.18	Бөөр шилжүүлэн суулгах эмчилгээний зааврыг шинэчлэн батлуулна.	-	ЭМС-ын тушаалаар батлагдсан эмчилгээний заавар	ЭМС-ын 2014 оны “Заавар батлах тухай” 74 тоот тушаал	Эмчилгээний заавар зохих хурлуудаар хэлэлцэгдэн ЭМЯ-нд хүргэгдсэн байна.	Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн бөөр шилжүүлэн суулгах багийн эмч нар тус эмчилгээний зааврыг шинэчлэн боловсруулж, УНТЭ-ийн “Эрдэмтдийн зөвлөл”-өөр 2025.11.28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлж, сайжруулах санал зөвлөмжийг тусган ажиллаж байна.	70%
4.19	Хорт хавдрын дараах бай эмчилгээнүүдийг өөрийн эмнэлэгт бүрэн нутагшуулна - Хэрх үений бай эмчилгээ - Цусны хавдрын бай эмчилгээний 2-3 дугаар эгнээний 1-2 бай эмчилгээ	-	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	5-10 тохиолдолд амжилттай хийсэн байна.	Цусны хавдрын бай эмчилгээний 2-3 дугаар эгнээний эмчилгээ болох Акалабрутиниб эмийг 2 тохиолдолд, Понатиниб эмийг 2 тохиолдолд шинээр эмчилгээнд нэвтрүүлж, өвчтөнүүдийн 3,6,12 дахь сарын үр дүнг хянаж байна, одоогоор эмчлүүлэгчдийн биеийн байдал тогтвортой байна. Хэрх, үений бай эмчилгээг нэвтрүүлэх чиглэлээр МУ-д батлагдсан эмчилгээний заавар,	100%

						удирдамжид орсон хэрх үе, холбогч эд, аутоиммуны эмгэгийн үед зайлшгүй хэрэглэх шаардлагатай bDmard's бай эмчилгээ нэвтрүүлэх төслийг бичиж, дотрын салбар зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Төсөл дэмжигдэж батлагдсан тохиолдолд санхүүжилтийг шийдвэрлэх эрх бүхий газруудад хүргүүлнэ.	
4.20	Хэвлийн дурангийн болон толгой, хүзүү, урологийн, ерөнхий мэс заслын хорт хавдрын үеийн лимфдиссекшн технологиудыг тусламж үйлчилгээнд нэвтрүүлнэ.	-	Амжилттай хийгдсэн тохиолдлын тоо	Эмч, мэргэжилтэн бэлтгэгдсэн	Нийт 10-аас доошгүй тохиолдолд амжилттай хийсэн байна.	ЧХХСМЗТ-т хүзүүний лимфдиссекшн 2 тохиолдол, шүлсний том булчирхай авах мэс засал 1 тохиолдол тус бүр амжилттай хийгдсэн. УАТ-д хэвлийн дурангаар бөөр авах, булчирхай түүх мэс засал эмчилгээг 3 тохиолдолд тус тус хийж шинэ технологи нэвтрүүлсэн.	100%
4.21	Хорт хавдрын дараах хими эмчилгээг өөрийн эмнэлэгт хийж, 10 ортой нэгж байгуулна.	-	- Нэгж байгуулсан тушаал, журам - Хими эмчилгээнд хамрагдсан үйлчлүүлэгчийн тоо -Хими эмчилгээний төрөл	7 чиглэлээр 1200 удаагийн сеанс хими эмчилгээ хийгдсэн байна.	Нэгж байгуулагдаж, хорт хавдрын дараах тусламж үйлчилгээний төрөл болон тоон үзүүлэлтийг нэмэгдүүлсэн байна.	Бүдүүн шулуун гэдэсний мэс заслын тасагт хорт хавдрын дараах хими эмчилгээний 10 ортой нэгж байгуулан, БШГМЗТ-ийн эрхлэгч Э.Бат-Өлзий эмч хариуцан ажиллаж байна. Хими эмчилгээний 2 эмчтэй, 2025 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар 87 хавдарын тохиолдолд мэс засал эмчилгээ хийсэн, нийт оношийн хамааралтай 7 бүлгээр 161 эмчлүүлэгчид 750 удаагийн сеанс хими эмчилгээ хийгдсэн. Эмнэлгийн захирлын 2025 оны А/333 тоот тушаалаар 9 хүний бүрэлдэхүүнтэй хавдрын зөвлөл	100%

						байгуулагдсан, зөвлөлийн даргаар БШГМЗТ-ийн эрхлэгч Э.Бат-Өлзий ажиллаж байгаа бөгөөд эмнэлгийн хэмжээнд мөрдөн ажиллах “Хими эмчилгээний журам”-ыг боловсруулан зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болсон.	
ЗОРИЛТ 5: Хүний нөөцийн хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг сайжруулах, бүтээмжийг нэмэгдүүлэх							
5.1	Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ бусад холбогдох журмыг шинэчлэн батлуулж ажилтнуудад зориулсан эрх зүйн гарын авлага гаргана.	-	– Шинэчилж батлагдсан журмууд – Хэвлэгдсэн гарын авлага	2022 онд дотоод журам шинэчлэгдсэн.	Журам шинэчлэгдэн батлагдаж, гарын авлага хэвлэгдсэн байна.	УНТЭ-ийн хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг шинэчлэн боловсруулах ажлын хэсгийг байгууллагын ерөнхий захирлын 2024.02.27-ны өдрийн А/55 тушаалаар 8 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажилласан. ЗХНА болон ажлын хэсгийн гишүүд байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг шинэчлэн боловсруулж, нийт ажилтнуудаас цахимаар болон цаасаар 2-3 удаа санал авч, удирдлагын түвшинд 4-5 удаа хэлэлцүүлэн, хуулийн зөвлөх болон хуулийн фермээс 2 удаа санал авч хянуулсан. Шинэчлэн боловсруулсан хөдөлмөрийн дотоод журам нь эмнэлгийн захирлын 2025 оны А/360 тоот тушаалаар батлагдсан.	100%
5.2	Гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулан эмнэлгийн захирлаар батлуулж, ажилтнуудын	-	– Батлагдсан шалгуур үзүүлэлт – Үнэлгээнд хамрагдсан	-	Нийт ажилтнуудын 30% нь гүйцэтгэлийн үнэлгээнд	Захиргаа, хүний нөөцийн алба нь эмч нарын чадамжийн шалгуурыг онолын, эмнэлзүйн, эмнэлзүйн бус чадамжаар үнэлэхээр эмнэлзүйн төв тасгуудаас санал авч байна.	100%

	гүйцэтгэлийг болно.	үнэлдэг		ажилтнуудын тоо		хамрагдсан байна.	1.Онолын чадамж /ажилтны ерөнхий мэдээлэл 2.Тайлангийн хэсэг /эмч, ажилчдын үзлэгийн болон ажлын гүйцэтгэлийн мэдээлэл/ 3. Эмнэлзүйн бус чадамжийн хэсэг /Төрийн албан хаагчид тавигдах шаардлагын дагуу/ 4. Эмнэлзүйн чадамжийн хэсэг /эмнэлзүйн нэгжид ажилдаггүй ажилтнуудад өөр/ Ажилтнуудын чадамжийг үнэлж гүйцэтгэлийн үнэлгээтэй уялдуулах ажлыг УНТЭ-н 2025-2028 онд хэрэгжүүлэн ажиллах стратеги төлөвлөгөөнд тусгасан. Үүнд: Эмч болон сувилагчийн цогц чадамжийг үнэлэх шалгуурыг боловсруулж, үнэлгээг жил бүр хийх, цалин хөлстэй уялдуулах /KPI/. Эмнэлзүйн нэгжийн эмч нарын багийн онолын ур чадварын үнэлгээг 228 эмчийг буюу нийт эмч нараа 100 хувь оролцуулан хийсэн. 2025 оын 11 сард ЗХНА-аас 22 тасаг нэгжийн 219 эмч нарын амбулатори болон стационарт хийсэн үзлэгийн тоон мэдээлэл, идэвхтэй хяналт, эмчийн эмчилгээ болон мэс ажилбар хийсэн үр дүнг тоон мэдээллээр нэгтгэн гаргаж гүйцэтгэлийн үнэлгээ хийсэн. Мэдээлэл технологийн алба, Захиргаа, хүний нөөцийн албадууд	
--	------------------------	---------	--	--------------------	--	----------------------	---	--

						хамтран мэс заслын өрөөний ашиглалт болон эмч, эмнэлгийн ажилтны ажлын бүтээмжийг үнэлэх үйл ажиллагаанд IoT технологийг ашиглан автоматжуулж байгаа бөгөөд системийг мэс заслын өрөөнүүдээс эхлэн нэвтрүүлж байна.	
5.3	Хөдөлмөрийн сахилга бат, байгууллагын соёл, ажилтнуудын харилцаа хандлагыг сайжруулах сургалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах - Монголын зөөлөн ур чадварын нийгэмлэг - Монголын Бурханы Шашинтны Төвийн “Лэгмон төв” - Удирдлагын академи - Хувь хүний хөгжлийн институт - Холбогдох төрийн байгууллагуудтай хамтарсан эрх зүйн сургалт	Төсөл хөтөл бөр	- Сургалтын тайлан, батлагдсан хөтөлбөр, удирдамж - Хамрагдсан ажилтнуудын тоо	-	Нийт ажилтнуудын 80-90 хувийг сургалтад бүрэн хамруулсан байна.	УНТЭ-ийн Захиргаа, хүний нөөцийн албанаас 2025 оны туршид зохион байгуулсан сургалтууд: 1. УНТЭ-ийн ерөнхий захирлын 2023.02.16-ны өдрийн А/51 тоот тушаалаар “УНТЭ-ийн хүний нөөцийн сургалт, хөгжлийн журам”-ыг баталж мөрдөн ажиллаж байна. Журмын дагуу УНТЭ нь 2025.01.01-2025.11.17-ны хугацаанд Эмнэлгийн захиргаа, эмнэлгийн дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний Ёс зүйн салбар хороо, эмнэлгийн дэргэдэх Ёс зүйн дэд хороо, эмнэлгийн Үйлдвэрчний эвлэлийн хороотой хамтран удирдлага манлайлал, харилцаа хандлага, ёс зүй, хөдөлмөрийн сахилга батыг сайжруулах чиглэлд нийт 58 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулж нийт ажилтнуудыг бүрэн хамруулсан байна.	100%

						2. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/172 тоот “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн нийт ажилтнуудын хандлага, хариуцлагыг нэмэгдүүлэх аян”-ыг 2025.06.03-2025.09.03 хугацаанд зохион байгуулах тушаал батлагдаж аяны хүрээнд нийт 20 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 1650 ажилтан хамрагдсан. <i>(Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан)</i>	
5.4	Шаардлагатай албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж эмнэлгийн захирлаар батлуулна.	-	Батлагдсан албан тушаалын тодорхойлолт	Бүрэн шинэчлэгдэж байгаагүй	50 албан тушаалын тодорхойлолт шинэчлэгдсэн байна.	Байгууллагын ерөнхий захирлын 2024.11.25-ны өдрийн А/371 тушаалаар “Албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах” ажлын хэсгийг 24 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж байна. 2025.11.01-ний өдрийн байдлаар 52 албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан нь 2025 оны зорилтдоо бүрэн хүрсэн.	100%
5.5	Эмнэлгийн ажилтнуудад хууль эрх зүйн мэдлэг олгох видео хичээлийн цахим сан үүсгэн гадаад дотоод цахим хуудсанд байршуулна.	-	-Үүсгэсэн видео хичээлийн сан -Цахим санд хандсан ажилтнуудын тоо	Анх удаа хийгдэнэ	Хэрэглэхэд хялбар эрх зүйн цахим сан үүсэж, хэрэглээнд нэвтэрсэн байна.	Захиргаа, хүний нөөцийн алба нь Арслан.мн сайттай хамтран эмнэлгийн ажилтнуудад зориулсан мэдлэг олгох, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх цахим хичээлүүдийн санг доорхи сэдвээр үүсгэн ашиглаж байна. Үүнд: ➢ Байгууллагын танилцуулга ➢ Эмнэлгийн түүх	100%

						➤ Байгууллагын хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ ➤ Хөдөлмөрийн дотоод хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, зөрчлийн тухай ➤ Төрийн албан хаагчийн хувийн хэргийн бүрдэл ➤ Олон нийтийн сүлжээг хэрхэн зөв зохистой ашиглах ➤ Эмнэлгийн e-health цахим системийн тухай	
5.6	Шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллана.	-	-Батлагдсан хөтөлбөр -Хөтөлбөрт хамрагдсан шинэ ажилтнуудын тоо	Шинэ сувилагч нарын хөтөлбөр хэрэгждэг	Шинэ ажилтнууд хөтөлбөрт бүрэн хамрагдсан байна.	Эмнэлгийн ерөнхий захирлын 2025.11.11-ний өдрийн А/308 тоот тушаалаар “Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг, 2025.11.11-ний өдрийн А/309 тоот тушаалаар “Шинэ ажилтныг чиглүүлэх, дасан зохицох хөтөлбөр”-ийг тус тус баталж мөрдөн ажиллаж байна. Захиргаа, хүний нөөцийн алба нь шинэ ажилтнуудад зориулсан чиглүүлэх 11 сэдэвт сургалтыг хөтөлбөр удирдамжийн дагуу 1. 2025.04.10-ны өдөр 25 ажилтанд 2. 2025.06.26-ны өдөр 25 ажилтанд 3. 2025.08.25-ны өдөр 32 ажилтанд 4. 2025.09.29-ний өдөр 16 ажилтанд тус тус зохион байгуулсан болно .	100%

5.7	Авлига, ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан ханган ажиллана.	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	Жил бүр төлөвлөгөө батлуулан ажилладаг.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	УНТЭ-ийн эрх бүхий албан тушаалтан нь 2025 онд авлигын эсрэг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг 4 чиглэлээр 23 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар боловсруулан батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 100%. (Батлагдсан төлөвлөгөө болон хэрэгжилтийн тайланг хавсралтаас харна уу)	100%
ЗОРИЛТ 6: Чанарын менежментийн тогтолцоог нутагшуулах /MNS ISO 9001:2016 стандарт/							
6.1	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын мэдлэг сэргээх сургалтыг зохион байгуулна.	-	- Сургалт зохион байгуулсан тайлан - Хамрагдсан ажилтны тоо	2023 онд эмнэлгийн хэмжээнд сургалт зохион байгуулсан	2-3 удаагийн сургалт эмнэлгийн хэмжээнд зохион байгуулагдсан байна.	2025 оны 05 сарын 20-21-ний өдрүүдэд “Чанарын менежментийн тогтолцоо ISO 9001:2015” стандартын аудитор бэлтгэх сургалтыг эмнэлгийн хэмжээнд 2 түвшинд зохион байгуулж, нийт 313 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтэн, захиргаа болон дэмжих үйлчилгээний ажилтнуудыг хамруулсан. Сургалтын төгсгөлд мэдлэг сорих шалгалтыг асуумжаар авч үнэлгээ хийсэн.	100%
6.2	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын аудитын сургалт зохион байгуулж шинэ аудиторуд бэлтгэнэ.	-	- Сургалтын тайлан - Бэлтгэгдсэн аудиторын тоо	2023 онд 32 аудитор бэлтгэгдсэн	10-15 шинэ аудитор сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан байна.	Эмнэлгийн хэмжээнд нийт 60 стандартын аудитор шинээр бэлтгэгдсэн.	100%

6.3	Чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандартын аудитад төв, тасаг, албадыг бүрэн хамруулна.	-	- Эмнэлгийн захирлын тушаалаар батлагдсан төлөвлөгөө - Аудит хийсэн тоо - Үл тохирлын нэгдсэн тайлан	2024 онд 28 төв, тасаг, албад аудитад хамрагдсан.	39 төв, тасаг, албад аудитад бүрэн хамрагдсан байна.	2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрөөс 10 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл Захирлын ажлын алба, Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба хамтран “Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн чанарын менежментийн тогтолцоо-шаардлага MNS ISO 9001:2016 стандарт”-ын хүрээнд аудит хийх төлөвлөгөө болон удирдамжийг боловсруулж, эмнэлгийн захирлаар батлуулан захиргааны болон дэмжих үйлчилгээний 15 алба, эмнэлзүйн 25 төв, тасаг нийт 40 нэгжээс 38 нэгжийг хамруулан стандартын дотоод аудит хийсэн. Аудитад хамрагдсан нэгж бүрд аудитын тайлан зөвлөмж бичигдсэн бөгөөд эмнэлгийн хэмжээнд нэгдсэн үл тохирлын тайлан бичигдэж эмнэлгийн удирдлагуудад танилцуулагдсан.	100%
ЗОРИЛТ 7: Сургалт эрдэм шинжилгээ, судалгаа, гадаад дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх							
7.1	“Эрдмийн чуулган - 46” байгууллагын 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулна.	200.0 (үйл ажиллаг ааны орлого)	– Хэвлэгдсэн товхимол – Ажлын тайлан	45 удаа зохион байгуулагдсан	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	УНТЭ-ийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан олон улсын эрдэм шинжилгээний хурал буюу нь “Эрдмийн чуулган - 46” нь “Past, Present and Future” сэдвээр 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр мэс засал, дотор, сувилахуй болон бусад гэсэн 4 чиглэлээр амжилттай зохион байгуулагдсан. Олон улсын хуралд Монгол улсын хэмжээнд тусламж үйлчилгээ үзүүлж буй эрүүл мэндийн	100%

						байгууллагуудын болон АНУ, Австрали, Тайван, БНСУ, ХБНГУ зэрэг 14 орны эрдэмтэн, судлаач, клиникийн профессор, докторууд оролцож илтгэл судалгаагаа танилцуулсан.	
7.2	Эмнэлгийн удирдлагын багийг чадавхжуулах гадаад ба дотоодын сургалтыг зохион байгуулна.	Төсөл хөтөл бөр	-Сургалтын тайлан -Хамрагдсан ажилтны тоо	Жил бүр зохион байгуулагддаг	1-2 удаа дотоод нэгдсэн сургалт, 1-2 удаагийн гадаад сургалтад хамрагдсан байна.	2025 оны 1 сард БНСУ-ын Улсан хотын Улсан их сургуулийн эмнэлэгт 8 хүний бүрэлдэхүүнтэй баг эмнэлзүйн удирдлагын чиглэлээр сургалтад хамрагдсан. 2025 оны 3 дугаар сард Захиргаа, хүний нөөцин, Захирлын ажлын алба хамтран “Удирдах ажилтны зөвлөгөөн 2025” сургалт зөвлөгөөнийг зохион байгуулж нийт 54 эмнэлгийн удирдах албан тушаалтнууд хамрагдсан.	100%
7.3	“Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал” индекс S(s) 091906 чанарын менежер бэлтгэх, сургалтын хөтөлбөр боловсруулж сургалт эрхлэх зөвшөөрөл авна.	-	– Эрх авсан тушаал шийдвэр – Батлагдсан сургалтын хөтөлбөр	-	Батлагдсан хөтөлбөрийн дагуу 1-2 удаа сургалт зохион байгуулагдсан байна.	УНТЭ-ийн ЭМТҮЧАБА нь төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулах зохих бэлтгэл шаардлагуудыг ханган, үнэлгээ хийлгэж тэнцсэн тул 2025 оны 03 дугаар сарын 25-нд Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй “Эмнэлгийн тусламжийн чанар, аюулгүй байдал” төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэшлийн сургалт зохион байгуулах гэрээ байгуулсан. Уг хөтөлбөрийн дагуу ЭМС-ын 2025 оны А/250 тоот тушаалаар 2 их эмч элсэж, амжилттай суралцаж төгссөн.	100%

7.4	“Элэгний эмгэг, урхаг хүндрэлийн менежмент 2025” үндэсний хэмжээний сургалтыг зохион байгуулна.	-	– Тайлан, мэдээ – Оролцсон эмнэлгийн мэргэжилтнүүд ийн тоо	Жил бүр зохион байгуулдаг	Сургалт зохион байгуулагдсан байна.	Тус сургалтыг Гастроэнтерологийн төв 2025.03.17-нд зохион байгуулж нийт 145 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд оролцсон.	100%
7.5	Монголын нефрологийн холбоотой хамтран “Бөөр судлалын үндэсний VI дугаар семинар”-ыг зохион байгуулна.	-	– Өдөрлөг, сургалтын тайлан, мэдээ – Оролцсон эмнэлгийн мэргэжилтнүүд ийн тоо	2020-2024 онуудад тасралтгүй зохион байгуулсан.	Сургалт зохион байгуулагдсан байна.	УНТЭ-ийн Бөөрний төв нь Монголын нефрологийн холбоотой хамтран “Бөөр судлалын үндэсний VI семинар”-ыг 2025 оны 11 сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулж, нийслэл болон орон нутгийн 100 гаруй бөөрний эмч нар хамрагдсан. Тус хуралд Бөөрний төвийн их эмч Б.Халиун “Аутосомын доминант хэлбэрээр удамших бөөрний олон уйланхайтах өвчний эмнэлзүйн судалгаа” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.	100%
7.6	Суралцагч нарын сургалтын орчныг сайжруулж засвар үйлчилгээ хийнэ.	Төсөл хөтөл Бөр	- Зарцуулсан төсөв – Хийсэн ажлын тайлан	Төслүүд хэрэгжиж байсан	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	УНТЭ-ийн 7 давхрын Сургалтын төвийн тохижилт үйлчилгээний "Зураг төсөл" бэлэн болж засварын ажил эхлэхээр хүлээгдэж байна.	50%
7.7	БНСУ-ын “ASAN” эрүүл мэндийн төвд нойр булчирхай шилжүүлэн суулгах давтан сургалтад эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдээ хамруулна.	Төсөл хөтөл бөр	- Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо - Сургалтын тайлан	2022, 2023 онуудад хамрагдсан	1-2 удаагийн сургалтад багаараа хамрагдсан байна.	БНСУ-ын “ASAN” эрүүл мэндийн төвийн элэг, цөс, нойр булчирхайн тасагт мэс заслын чиглэлээр 3 эмч, 1 сувилагч сургалтад хамрагдсан.	100%
7.8	“WBMT symposium work shop” буюу буюу “Дэлхийн үүдэл эс шилжүүлэн суулгах нийгэмлэг”-ийн	Төсөл хөтөл бөр	Хурлын тайлан, мэдээ, оролцсон зочид	Анх удаа	Хурал семинарыг зохион байгуулж төлөвлөсөн арга	УНТЭ-ийн ЦЭСЧШСТ нь Дэлхийн цусны үүдэл эс шилжүүлэн суулгах нийгэмлэгийн /WBMT/ 9 дахь workshop уулзалт, сургалтыг 2025	

	Олон Улсын хурлыг зохион байгуулах (36 орны зочид төлөөлөгчид оролцоно)		төлөөлөгчийн тоо		хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	оны 06 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулж, Монгол, АНУ, Япон, ХБНГУ, БНХАУ, Их Британи зэрэг дэлхийн 30 гаруй улсын цус судлалын салбарын тэргүүлэх 50 гаруй эрдэмтэн, судлаач, эмч, мэргэжилтнүүдийг урьж оролцуулан туршлага, мэдлэгээ солилцсон.	100%
ЗОРИЛТ 8: Цахим эрүүл мэндийн тогтолцооны хөгжүүлэлт, мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах, телемедицины үйл ажиллагааг өргөжүүлэх							
8.1	Мэдээллийн аюулгүй байдлын аутсорсинг үйлчилгээ авч аюулгүй байдлын болон эрсдэлийн үнэлгээ хийлгэнэ.	20.0 (үйл ажиллагааны орлого)	– Батлагдсан гэрээ, – Үнэлгээний тайлан	2022 онд үнэлгээ хийгдсэн.	Мэдээллийн аюулгүй байдлын үнэлгээ хийгдэж, эрсдэлийг бууруулсан байна.	Мэдээлэл технологийн алба нь 2025 оны 05 сарын 05-ны өдрийн 1/702 тоот албан бичгээр зөвлөх үйлчилгээний байгууллагуудаас үнийн санал авах хүсэлтийг хүргүүлж “Монголын стандарт, чанарын хүрээлэн” НҮТББ шалгаран хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хамтран ажиллах гэрээний хүрээнд 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрөөс 09 дүгээр сарын 10-ний хооронд ISO/IEC 27001:2022 Мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдал болон нууцлалын хамгаалалт, мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны зөрүүгийн шинжилгээг хийж үр дүнг удирдлагын багт танилцуулсан.	100%

8.2	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	-	– Зөвлөх үйлчилгээний гэрээ, – Ажлын тайлан	2023 онд MNS ISO 9001:2016 стандартыг нэвтрүүлсэн.	Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо MNS ISO/IEC 27001:2022 стандартыг нэвтрүүлэх ажлыг “Монголын стандарт, чанарын хүрээлэн” НҮТББ-тай УНТЭ 69/25 зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулан хийж байгаа бөгөөд 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар “Мэдээллийн аюулгүй байдлын бодлого” болон холбогдох эрхзүйн баримт бичгүүд болох 20 гаруй журмыг боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна.	100%
8.3	Байгууллагын гадаад цахим хуудсыг шинэчилнэ.	-	– Ажил гүйцэтгэх гэрээ - Акт дүгнэлт	2019 онд цахим хуудасны хөгжүүлэлтийн гэрээ дууссан.	Гадаад цахим хуудас бүрэн шинэчлэгдсэн байна.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, байгууллагын гадаад цахим хуудасны хөгжүүлэлтийг сайжруулах зорилгоор МТА, ЗАА хамтран “Содон Солушн” ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулан байгууллагын гадаад цахим хуудсыг шинэчилсэн.	100%
8.4	Эмнэлгийн үйл ажиллагааны процессыг кодлон автоматжуулах ажлыг эхлүүлэх	-	- Автоматжуулсан процессын тоо	Анх удаа хийгдэнэ.	Сонгогдсон тасаг нэгжийн үйл ажиллагааны процессыг бүрэн кодлосон байна	ЭМС-ын 2025 оны 03 сарын 31-ний өдрийн А/102 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалын дагуу эмнэлгийн сувिलाхуйн үйл ажиллагаанд хөтлөгдөж буй бичиг баримтыг кодлох ажил хийгдэж эхэлсэн бөгөөд ажлын хэсгийн гишүүд 3 багт хуваагдан Зүрхний төв болон Гастроэнтерлогийн төвийн үйл ажиллагаатай	100%

						танилцаж мөрдөгдөж буй хууль эрхзүйн баримт бичгийн хүрээнд сувилагчийн хөтөлж буй цаасан болон цахим маягтад хяналт хийж, давхардлыг арилгахаар ажилласан. Тус ажлын хүрээнд МХНТ-т хэрэглэгддэг 5 маягтыг цахимжуулж e-Health програмд оруулсан. Мөн санхүүгийн програмд бүртгэгдсэн эмийн баркодыг “Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийг эрчимжүүлэх, шаардлагатай төсөл арга хэмжээний жагсаалт, төсөв”-ийг баталсан ЭМС-ын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа төслийн хүрээнд хөгжүүлсэн “УНТЭ” аппликейшнтэй холбон сувилагч эмийн зарлага хийхдээ үйлчлүүлэгчийн баркод бугуйвч болон эмийн баркодтой тулгаж эмийн эмчилгээний зарлагыг хийх боломжийг бүрдүүлсэн.	
8.5	МУЗГҮАХ 2.32.6 МУХТ 3.3.15 Телемедицинский технологийг ашиглан зайн оношилгоог хөгжүүлэх, дүүрэг, орон нутгийн эмнэлгүүдэд газар зүйн байрлал хамаарахгүйгээр тусламж үзүүлж мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.	-	Зайн оношилгоогоор холбогдсон болон мэргэжил арга зүйгээр ханган ажилласан эмнэлгүүдийн тоо	2022 оноос эхлэн зайн оношилгооны төсөл зогссон	Зайн оношилгооны үйл ажиллагаа тогтмолжсон байна.	2025 оны 8 дугаар сар хүртэл УХТЭ-ийн дэргэд байрлах Зайн оношилгооны төвд сар бүр УНТЭ-ийн Дүрс оношилгооны төвийн 1 эмч томилогдон ажилласан бөгөөд 2025 оны 8 сараас тус төвийн үйл ажиллагаа зогссон. УНТЭ-ийн хувьд иргэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран түргэн шуурхай авах	100%

						боломжийг нэмэгдүүлэн ажиллах зорилгоор “Телемедициний тусламж үйлчилгээг зохицуулах журам”-ыг боловсруулан, эмнэлгийн захирлын 2025.11.10-ны өдрийн А/325 тоот тушаалаар баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж эхлээд байна.	
8.6	МУХТ 3.3.15 Онлайн амбулаторийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгооны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	-	- Цахим амбулаторийн кабинетын тоо - Үйлчилгээ авсан иргэдийн тоо	Анх удаа хийгдэнэ	3-4 кабинетыг онлайн тусламж үйлчилгээтэй болгосон байна.	2025 оны 01 сарын 03-ны өдрөөс эхлэн Хан-Уул дүүргийн нийт 25 өрхийн эрүүл мэндийн төвтэй MS Teams програмыг ашиглан холболт хийж “Онлайн эмнэлэг” төслийг эхлүүлэн Хэрх үе судлал, Бөөр судлал, Урологи, Цусны эмгэг судлалын эмчийн үзлэгийг цахим хэлбэрээр хийж нийт 3776 иргэн үзлэгт хамрагдсан байна.	100%
ЗОРИЛТ 9: Гамшгийн үеийн бэлэн байдлыг ханган ажиллах, шинэ болон сэргэж байгаа халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх							
9.1	МУХТЖҮЧ 2.2.1 Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үзүүлэх сургуулилалт зохион байгуулна.	-	- Үзүүлэх сургуулилалт хийсэн тайлан - Хамрагдсан ажилтны тоо	Жил бүр зохион байгуулагддаг	Холбогдох төв, тасаг, алба, нэгжүүд үзүүлэх сургуулилтад бүрэн хамрагдсан байна.	УНТЭ-ийн Халдварын сэргийлэлт, хяналтын алба, Нийгмийн эрүүл мэндийн алба, Яаралтай тусламжийн тасаг, Уушги, харшил судлалын төвүүд хамтран Олон улсын эрүүл мэндийн дүрмээр зохицуулагддаг шинэ болон сэргэж буй халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зөв авах, зохион байгуулалтыг хэвшүүлэх, бэлэн байдлыг хангах зорилгоор 2025.01.03-ны өдөр болон 2025.11.27-ны өдрүүдэд “Улирлын томуу, томуу төст өвчний дэгдэлтийн бэлэн байдлыг хангах”	100%

						үзүүлэх сургуулилтыг 2 удаа зохион байгуулсан. (Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан)	
9.2	Эмнэлгийн төв байрны нийтийн эзэмшлийн талбайд галын утаа мэдрэгч, дохиоллын систем, стикер, галын булан тавьж галын аюулгүй байдлыг хангана.	19.0 (үйл ажиллаг ааны орлого)	– Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь, – Ажлын тайлан	2023 онд галын аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ дотооддоо хийсэн.	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Инженерийн байгууламжийн албанаас 2025 онд эмнэлгийн хэмжээний галын аюулгүй байдлыг ханган 19,5 сая төгрөгийн өртөг бүхий Гал унтраагуур - 90, Гал унтраагуурын суурь - 90, Хяналтын таг - 90, Галын Сарай – 4 иж бүрдэл зэрэг нэн шаардлагатай худалдан авалтыг хийж, төв, тасаг, нэгжүүдэд тараан байршуулсан. 2025.12.01-ний өдрийн байдлаар эмнэлэгт нийт 141 ширхэг галын хор, 27 ширхэг галын гидрантыг байршуулсан. Галын хорын бүртгэлийг төв тасаг нэгжээр нь жил бүр хийж, шаардлагатай газарт нэмэлтээр байршуулсан тэмдэглэлийг хөтөлдөг.	100%
9.3	Галын аюулгүй байдлын сургалтыг Сүхбаатар дүүргийн ОБЕГ-тай хамтран хийнэ.	-	– Сургалтын тайлан, удирдамж, – Хамрагдсан ажилтны тоо	2022 онд дотоодын сургалтыг төв тасаг нэгжид хийгдсэн.	Сургалт зохион байгуулагдсан байна	УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба, Яаралтай тусламжийн тасаг удирдан зохион байгуулж, Нийслэлийн онцгой байдлын газар, Сүхбаатар дүүргийн онцгой байдлын хэлтэс, Нийслэлийн иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвтэй хамтран “Гал түймэр гарсан үед эрүүл мэндийн байгууллагын авах арга хэмжээ”сэдэвт үзүүлэх сургалтыг 2025 оны 12 дугаар	100%

						сарын 03-ны өдөр зохион байгуулж УНТЭ-ийн 118 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүд хамрагдсан. Мөн 2025.12.03-ны өдрийн эмч нарын ярианд “Гал түймрээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангах” сэдэвт сургалтыг ОБЕГ-ын харьяа Сүхбаатар дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн хяналтын улсын байцаагч, ахмад Д.Ариунзаяа удирдан явуулсан. (Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан)	
9.4	Эмнэлгийн 4 нөөц үүсгүүрийн бэлэн байдлыг ханган ажиллана.	12.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Бэлэн байдлыг хангасан нөөц үүсгүүрийн тоо - Гэрээ дүгнэсэн акт	Засвар үйлчилгээний гэрээ 2024 онд хийгдсэн.	2025 оны гэрээ байгуулагдаж төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	УНТЭ-ийн хэмжээнд нийт 4 нөөц үүсгүүр буюу генератор ажиллаж байгаа бөгөөд Монхорус ХХК- нь шаардлагатай тохиолдолд техникийн үзлэгийг хамтран зохион байгуулж, бэлэн байдлыг ханган ажилласан. Эдгээрээс техникийн үзлэгийн явцад 1 генератор ашиглалтаас гарсан бөгөөд хуулийн дагуу худалдан авалтыг зохион байгуулж, 2025 оны 12 сарын 05-нд “Генератор ХАБ” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу дизель генератор 1 ширхэгийг шинээр худалдан авч суурилуулсан. Тус генератор нь эрчимт эмчилгээний тасаг, зүрхний төв, мэдрэлийн эмнэлзүйн төвийн цахилгааны нөөцийн үүсгүүр болно.	100%

9.5	Эмнэлгийн аянга зайлуулагч, газардуулгын болон цахилгаан энергийн хэмжилт хийлгэнэ.	30.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Газардуулгын протокол, дүгнэлт - Хийсэн ажлын тайлан	2023 онд хийгдсэн.	Хэмжилтийн протокол гарч төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.	Эмнэлгийн аянга зайлуулагч, газардуулгын болон цахилгаан энергийн хэмжилт 2025 оны 09 сард хийлгэсэн, протокол, дүгнэлт хүлээгдэж байна.	100%
9.6	Цацрагийн гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн батлуулж хэрэгжилтийг ханган ажиллана.	-	- Шинэчилсэн төлөвлөгөө - Хэрэгжилтийн тайлан	2021 онд батлагдсан	Эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулсан төлөвлөгөө, тухайн жилийн хэрэгжилтийн тайлан	УНТЭ-ийн ДОТ-ийн Цөмийн онош зүйн тасаг нь 2025 оны 10 сард “УНТЭ-ийн цацрагийн гамшгийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө”-г шинэчлэн боловсруулж, эмнэлгийн удирдлагаар батлуулан хэрэгжилтийн ханган ажиллаж эхлээд байна.	100%
ЗОРИЛТ 10: Үндэсний хэмжээнд болон эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллах							
10.1	МУЗГҮАХ 2.3.1.2 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллана.	-	- Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн хувь	2024 онд батлагдсан.	Төлөвлөсөн арга хэмжээнүүд бүрэн хэрэгжсэн байна.	УНТЭ нь өөрийн эрхэлж буй үйл ажиллагааны үндсэн чиглэл болох нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт сурталчилгааны болон өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна. Мөн эрүүл мэндийн салбарын хэмжээнд ЭМС-ын тушаалаар батлагдсан 6 арга хэмжээний төлөвлөгөө хэрэгжиж байгаа бөгөөд чиг үүргийн дагуух арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. (Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан)	100%

10.2	Дэлхийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлнэ.	-	- Хийсэн ажлын тайлан - Оролцсон үйлчлүүлэгчийн тоо	Жил бүр тэмдэглэдэг	Нийт 28 өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн байна.	УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба нь 2025 оны 12 сарын 01-ний өдрийн байдлаар Дэлхийн эрүүл мэндийн 26 тэмдэглэлт өдрийг холбогдох алба, эмнэлзүйн төв, тасгуудтай хамтран зохион байгуулж, тэмдэглэн өнгөрүүлсэн. (Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан)	100%
10.3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэд эрүүл мэндийн байгууллагаар саадгүй үйлчлүүлэх, мэдээлэл авах боломжоор хангах ажлын хүрээнд ажилтнуудын дунд дохионы хэлний сургалтыг зохион байгуулна.	1.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Сургалтын тайлан - Бэлтгэгдсэн ажилтны тоо	2020 онд зохион байгуулагдсан	Тасаг нэгж бүрээс 1 ажилтан сургалтад хамрагдаж бэлтгэгдсэн байна.	УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба, Сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасгууд санаачлан “Сонсголгүй иргэдийн үндэсний холбоо”-той хамтран “Харилцааны анхан шатны дохионы хэл” 3 удаагийн 12 багц цагийн сургалтыг зохион байгуулж 30 төв, тасгийн 29 эмч, сувилагч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан.	100%
10.4	Хүн амд зонхилон тохиолдох өвчин эмгэгээс сэргийлэх, эрүүл мэндийн боловсрол олгох контент, подкаст бэлтгэж ард иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох ажлыг тасралтгүй зохион байгуулна.	1.0 (үйл ажиллаг ааны орлого)	- Бүтээгдсэн контентийн тоо - Иргэдэд хандалт болон үзэлтийн тоо	2020 онд хийгдэж байсан.	Нийт 10-15 төрлийн контент эмнэлгийн цахим хуудас, фейсбүүк хуудсанд байршуулсан байна.	УНТЭ-ийн Нийгмийн эрүүл мэндийн алба нь захиргааны болон дэмжих үйлчилгээний албадууд, нийт эмнэлзүйн төв, тасгуудтай хамтран ард иргэдийн эрүүл мэндийн боловсролыг сайжруулах 20 гаруй удаагийн зөвлөгөө контент, сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр 128 постер, 8 рийл, “Эмч зөвлөж байна”, “Сувилагч зөвлөж байна” мэдээлэл ярилцлага 43, эмийн аюулгүй байдал зохистой хэрэглээний талаарх мэдээлэл 10	100%

						гаруй, цаг үеийн өвчлөлттэй холбоотой зөвлөмж мэдээллийг тухай бүрд бэлтгэж, УНТЭ-ийн фейсбүүк пэйж хуудсаар түгээдэг бөгөөд 50 мянга гаруй иргэнд хүрсэн, сүүлийн 90 хоногт 2.1 сая удаагийн хандалттай байна.	
10.5	“Эмийн аюулгүй байдлын 7 хоног” арга хэмжээг зохион байгуулна.	-	- Удирдамж - Хөтөлбөр - Арга хэмжээний тайлан	Жил бүр зохион байгуулдаг	Арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байна.	ДЭМБ-аас жил бүрийн 9 дүгээр сард “Эмийн зохистой хэрэглээний 10 хоногийн аян”-ыг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ жил тус аяныг “Цахим жор цаг хэмнэнэ” сэдвийн хүрээнд 2025 оны 09.17-09.25-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлсэн. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 100%	100%
10.6	“Бичил биетний тэсвэржилтийн дэлхийн 7 хоног” арга хэмжээг зохион байгуулна.	-	- Удирдамж - Хөтөлбөр - Арга хэмжээний тайлан	Жил бүр зохион байгуулдаг	Арга хэмжээг амжилттай зохион байгуулсан байна.	ЭМЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2025.11.11-ний өдрийн 2/5392 дугаартай албан бичгээр “Бичил биетний тэсвэржилтээс сэргийлэх дэлхийн 7 хоног”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай чиглэл ирсэн бөгөөд УНТЭ-ийн ЭМТҮЧАБА, ХСХА, Бичил биетний эсрэг эмийн дэд хороо болон эм зүйн албадууд хамтран “Ирээдүйнхээ аюулгүй байдлын төлөө өнөөдрөө хамгаалж, яг одоо хэрэгжүүлж эхлээ” багц цагийн сургалт зохион байгуулахаар удирдамж хөтөлбөрийг боловсруулж, эмнэлгийн захирлаар батлуулан, ЭМХТ-д хүргүүлсэн. Багц цагийн	100%

						зөвшөөрөл баталгаажсаны дараа сургалтыг зохион байгуулна, бэлтгэл ажлыг бүрэн хангасан. Мөн УНТЭ-ийн Бичил биетний эмийн дэд хорооноос ард иргэдэд зориулсан “Антибиотик тэсвэржилтээс сэргийлье”, “Антибиотик тэсвэржилт гэж юу вэ?”, “Эмийн зохистой хэрэглээг хэрхэн дадал болгох вэ?”, “Эмийг эмчийн заавраар хэрэглэхгүй бол ямар үр дагаварт хүрч болзошгүй вэ?” зэрэг олон мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэсэн.	
ЗОРИЛТ 11: Эмнэлгийн түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх болон хөрөнгө оруулалтын чиглэлээр							
11.1	Эмнэлэг үүсгэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлнэ.		– Батлагдсан төлөвлөгөө – Хэрэгжилтийн тайлан	2015 онд түүхт 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлсэн	Төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна	Улсын Нэгдүгээр Төв эмнэлгийн түүхт 100 жилийн ойг 2025 оны 10 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд 10 дугаар сарын 23-нд “Past, Present and Future” сэдвээр олон улсын эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан. 10 дугаар сарын 24-нд Соёлын төв өргөөнд түүхэн үзэсгэлэн, баярын хурал, хүндэтгэлийн концерт, баярын цэнгүүний арга хэмжээ тус тус зохион байгуулагдсан. УНТЭ нь түүхт 100 жилийнхээ ойгоор МУ-ын Ерөнхийлөгчийн зарлигаар “Хөдөлмөрийн баатар” эмнэлэг цол тэмдгээр шагнагдсан. Тушаал шийдвэрийн чиглэлээр:	100%

						1. Эмнэлгийн захирлын 2024.11.05-ны өдрийн А/347 тоот “УНТЭ-ийн түүхт 100 жилийн ойн арга хэмжээ, бэлтгэл ажлыг зохион байгуулах тухай” тушаалаар 10 чиглэлээр ажиллах эмнэлгийн удирдлагууд, төв тасгийн дарга, эрхлэгч, эмч, мэргэжилтэн нараас бүрдсэн 10 чиглэлээр ажиллах ажлын хэсгийн гишүүдийг томилсон. 2. Мөн арга хэмжээний төлөвлөгөө болон төсвийг эмнэлгийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025.07.08-ний өдрийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан. 3. Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/350 тоот “Тэгш ой тэмдэглэх тухай” тушаалаар эмнэлэг байгуулагдсаны 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зөвшөөрлийг авсан. <i>(Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан)</i>	
11.2	Засгийн газрын дэмжлэгтэй нийлүүлэгдэх эм савлалтын автомат машиныг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.	1,000 (улсын төсөв)	– Хүлээн авсан автомат машин – Гэрээ, акт дүгнэлт	Эм савлалтыг гараар савлаж байна.	Автомат савлалтын машиныг суурилуулсан байна.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор Улсын нэгдүгээр төв эмнэлгийн түүхт 100 жилийн ойн хүрээнд улсын хэмжээнд анх удаа “Эмийн чанар, үл нийцэл, хадгалалт, хяналт, нөөцийн удирдлага, автомат савалгааны цогц технологи” төслийг хэрэгжүүлэн эмнэлзүйн тусламж	100%

						үйлчилгээнд үе шаттайгаар амжилттай нэвтрүүлж эхлээд байна. Нийт төсөвт өртөг нь 1 тэрбум төгрөг бөгөөд ЭМЯ/20250102005 дугаартай “Эмийн автомат савлалтын машин бүхий агуулахын нэгдсэн систем” нээлттэй тендер шалгаруулалтыг зарлан 2025 оны 05 дугаар сарын 31-нд шалгаруулалтыг зохион байгуулж, Доктор Тун ХХК нь 15 ширхэг эм хадгалах ухаалаг шүүгээ, 1 ширхэг эмийн нэгж тунгийн автомат савлалтын машин бусад дагалдах хэрэгслийн хамт нийлүүлсэн. УНТЭ нь тус технологороо “MONGOLIA HEALTH TECHNOLOGY EXPO-2025” олон улсын үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож, “Шилдэг технологи нэвтрүүлэгч байгууллага”-аар шалгарсан. <i>(Дэлгэрэнгүйг хавсралт тайланд тусгасан)</i>	
11.3	1971 онд ашиглалтад орсон эмнэлгийн төв барилгын гадна фасадыг шинэчилнэ.	3,400 (улсын төсөв)	Шинэчилсэн фасадыг хүлээн авсан акт, дүгнэлт	Төв байр нь 1971 онд ашиглалтад орсон.	Эмнэлгийн төв барилгын гадна фасадны ажил бүрэн хийгдсэн байна.	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн барилгын гадна фасадын засварын ажлын тендерийг 2024 онд зарлаж, гүйцэтгэгчээр “Би Рич Трейд” ХХК шалгарч засварын ажлын гэрээг байгуулсан. 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс тус засварын ажил эхэлсэн бөгөөд 2025 оны 10 дугаар сард дуусаж, улсын комисс ажилласан.	100%

11.4	Амбулаторийн хэсгийн цэвэр, бохирын усны шугамын засварыг хийнэ.	1,600 (улсын төсөв)	Ашиглалтад оруулсан акт, дүгнэлт	1971 оноос хойш засвар хийгдээгүй.	Цэвэр бохирын шугамын засварын ажил бүрэн хийгдсэн байна.	Тус засварын ажлыг улсын төсвөөр хийж гүйцэтгэсэн бөгөөд тендерт ялсан “Түмт мөрөн” ХХК нь 2025.03.15-ны өдрөөс ажлаа эхлүүлж амбулатори буюу С блокын 1-5 давхар бүрэн хамрагдсан, эмнэлгийн зүгээс хийгдэх ажлууд бүрэн дууссан.	100%
11.5	Шинээр баригдаж буй хүчилтөрөгчийн үйлдвэрийг хүлээж авч ашиглалтад оруулна.	-	Ашиглалтад оруулсан акт, дүгнэлт	2023 онд НҮБ-ийн Хүүхдийн сангийн санхүүжилт	Хүчилтөрөгчийн үйлдвэрийг хүлээн авч ашиглалтад оруулсан байна.	Нэгдсэн үндэсний байгууллагын хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр эмнэлгийн хүчилтөрөгчийн үйлдвэрийн барилгын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн МЗХ2024/04-022 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгаврын зураг төсөл батлагдаж, 2025 онд нийт 122,2 м.кв талбай бүхий 1 давхар барилгыг стандартын дагуу барьж, улсын комисс ажиллуулахад бэлэн болсон.	100%
11.6	МУХТ 3.3.11 “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн барилга болон “Авто зогсоолын барилга”-ын ажлыг үргэлжлүүлнэ.	139,000 тэрбум (улсын төсвийн хөрөнгө)	Барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	2015 онд эмнэлгийн зүүн байр ашиглалтад орсон	“Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв”-ийн барилгын гүйцэтгэл 20%-тай байна. Авто зогсоолын барилга бүрэн ашиглалтад орсон байна	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тусгагдсан “Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төвийн барилга” /А блок/, “Авто зогсоолын барилга” /Б блок/-г барих тендерийг зарлаж, гүйцэтгэгч компаниар Магнус сентурион констракшн ХХК шалгарч, Эрүүл мэндийн яам болон Магнус сентурион констракшн ХХК 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдөр УТ2402002274 ХО/99 дугаартай гэрээ байгуулсан. 2025 оны 12	100%

						сарын 01-ний өдрийн байдлаар барилгын явц 40% гүйцэтгэлтэй байна. Авто зогсоолын барилгын ажил дуусаж, улсын комисс ажиллахад бэлэн болсон.	
11.7	Төвийн вен, артерийн судсанд гуурс байрлуулах, мэдрэлийн хориг хийж өвдөлт намдаах зэрэг ажилбарын үед хэрэглэгдэх хүчин чадал сайтай сүүлийн загварын ЭХО аппарат авна.	200.0 (төсөл хөтөл бөр)	– Бичсэн төсөл – Санхүүгийн тайлан	2 эхо аппараттай	Нэмэлтээр орчин үеийн өндөр хүчин чадалтай 1 эхо аппараттай болсон байна.	Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасагт шаардлагатай байгаа хүчин чадал сайтай ЭХО аппаратын хэрэгцээг үндэслэж, санхүүжилт дэмжлэг хүссэн төсөл бичиж Олон Улсын энэрлийн байгууллага болох “Дезерет” байгууллагад илгээсэн бөгөөд төслийн шалгаруулалтын шийдвэрийг хүлээж байна.	50%
11.8	Амбулаторийн 1 давхарын лавлагаа, цахим бүртгэлийн хэсэгт орчин үеийн шийдэл бүхий иж бүрэн засвар хийнэ.	400.0 (хөрөнгө оруулалт)	– Засварын тайлан	2019 онд засвар хийсэн	Лавлагаа, цахим бүртгэлийн хэсэгт бүрэн засвар хийгдсэн байна.	Амбулаторийн 1 давхарын цахим бүртгэл, угтах үйлчилгээний хэсэг болох нийт 556 м2 талбайд 595,0 сая төгрөгийн төсөв бүхий 2025.03.15-ны өдрөөс 2025.09.15-ны өдрийг хүртэл их засвар хийж, тохижуулан орчин үеийн загвар дизайнтай цахим бүртгэл, угтах үйлчилгээний хэсэгтэй болсон. Тус их засварын ажлын хүрээнд дараах ажлууд хийгдсэн. 1. Орчны иж бүрэн засвар тохижилтын ажлыг хандиваар 2. Стандартын агааржуулалтийн хоолой солих ажлыг хандиваар,	100%

						3. Утаа мэдрэгч 18 ширхэгийг суурилуулах ажлыг хандиваар 4. Цэвэр тохилог ариун цэврийн өрөө 12, үүнээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө 2 тохижуулах ажлыг хандиваар 5. Улсын төсвөөр 56 хуучин модон цонхыг вакум цонхоор сольсон 6. Улсын төсвөөр амбулаторийн хэсэгт хийгдсэн бохир, цэвэр усны шугамын засвар тус тус хийгдсэн.	
--	--	--	--	--	--	--	--

Төлөвлөгөө тайлагнасан:

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ
 ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
 (албан тушаал)

Тамга



(гарын үсэг)

/Л.БЯМБАСҮРЭН/

2025.12.24
 (огноо)